



2019

Жилийн тайлан

АГУУЛГА

Мэндчилгээ

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Товч танилцуулга

Монгол Улсын эдийн засаг 2019

Үндэсний хөрөнгө оруулалтын банк 2019

Банкны зохистой засаглал

Хувьцаа эзэмшигчид

Төлөөлөн удирдах зөвлөл

Гүйцэтгэх удирдлага

Банкны бүтэц, зохион байгуулалт

Эрсдэлийн удирдлага

Хүний нөөцийн удирдлага

Мэдээлэл технологи

Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан

Хараат бус аудиторын тайлан

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Бидний зүтгэлийг итгэлээр үнэлэн, хамтран ажиллаж, сонгон үйлчлүүлдэг эрхэм Харилцагч, Түнш байгууллагууд та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Олз омог амжилт бүтээлээр дүүрэн 12 жилийн ойтойгоо золгож буй Үндэсний Хөрөнгө Оруулалтын банк 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажлынхаа үр дүн, ололт амжилтаа эрхэм харилцагч, түнш байгууллагууд та бүхэнтэйгээ хуваалцаж өөрсдийн санхүүгийн тайлангаа хүргэж байгаадаа туйлын таатай байна.

Энэ онд Үндэсний хөрөнгө оруулалтын банк Эх орны хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтанд өөрсдийн бодит хувь нэмрийг оруулан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгынхоо хүрээнд томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллаж байна. Мөн харилцагч үйлчлүүлэгчид, түнш байгууллагууд болон хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн үр өгөөжтэй өндөр хариуцлагатай байж өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй үйлчлүүлэгчдийнхээ хүсэл сонирхолд нийцсэн шинэ, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлэн харилцан ашигтай хамтран ажиллалаа. Манай банкны нэр хүнд дотоод гадаадын харилцагчдын дунд эрчимтэй өсч харилцагчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 48 хувиар, татан төвлөрүүлсэн хөрөнгө 35.6 хувиар тус тус өсөн нэмэгдсэн таатай жил боллоо.

Эдгээр амжилтаа улам баталгаажуулах үүднээс цахим үйлчилгээгээ улам сайжруулан харилцагчдын таашаалд нийцүүлсэн нь харилцагч, үйлчлүүлэгчдийн тоо өсөн нэмэгдэх үндэс суурь болж байна. Бид зөвхөн бүтээгдэхүүн үйлчилгээнээс гадна нийгмийн хариуцлагын болон тогтвортой санхүүжилтын хүрээнд ирээдүйн шилдэг боловсон хүчнийг дэмжих зорилгоор оюутны сургалтын тэтгэлэг, эрдэм шинжилгээний бага хурлуудыг дэмжин ажиллаж, нийт хамт олноороо “Цус сэлбэлт үндэсний төв”-д цусаа хандивлах өдөрлөгийг зохион байгуулж, байгалийн гамшигт үзэгдэл болох ой хээрийн түймэрийн эсрэг улсын онцгой комисст мөнгөн тусламж үзүүлсэн зэрэг олон ажлуудыг санаачлан, дэмжин ажилласан байна.

Эрхэм харилцагч, түнш байгууллагууд та бүхний итгэлийг өндөрт өргөж, өөрсдийн мэргэшсэн чадварлаг хамт олнохоо хичээл зүтгэлээр банкны үйл ажиллагааг улам хөгжүүлэн ажиллах болно.



Таныг хүндэтгэсэн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ТУЛГА

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

АЛСЫН ХАРАА

Үндэсний баялаг бүтээгчдийн түнш, хөрөнгө оруулалтаараа тэргүүлэгч банк байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдаа дээдлэн, итгэлийг эрхэмлэн, санхүүгийн цогц үйлчилгээг шинэлэг хэлбэрээр баяжуулан түгээж, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулсан бүтээлч банк байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

ЭРХЭМ ХАРИЛЦАГЧ

Бид өөрийн харилцагч, үйлчлүүлэгчдийг эн тэргүүнд эрхэмлэн дээдлэх бөгөөд тэдний хүсэл зорилго, хэрэгцээнд нийцсэн өндөр чанар бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэн ажиллана.



БҮТЭЭЛЧ БАЙГУУЛЛАГА

Бид өөрийн ажилтнуудын итгэл үнэмшил бүхий нэгдсэн соёлыг төлөвшүүлэх бөгөөд ажилтан бүрээ эрхэмлэн хүндэлж, дэмжихийн зэрэгцээ шинэлэг, бүтээлч, манлайлагч хамт олныг бий болгох болно.

ШИНЭ ТЕХНОЛОГИ

Бид банкны системд гарч буй технологийн дэвшил, шинэчлэлтэд нээлттэй, уян хатан хандаж өөрийн бизнест орчин үеийн шинэ тутам хандлага, үйлчилгээг нэвтрүүлэхийг эрхэмлэнэ.



ҮР АШИГТ ГҮЙЦЭТГЭЛ

Бид үйл ажиллагааны үр өгөөжөө нэмэгдүүлж, үр ашигт зардлын менежмент, эрсдэл болон өгөөжийн зохистой харьцааг баримтлан ажиллах болно.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Бид байгаль орчин, өв соёлоо сахин хамгаалж, хүний эрх, ногоон эдийн засгийг дэмжин, нийгэмд хүлээсэн хариуцлагаа ухамсарлан ажиллах болно.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ - 2019

Эдийн засгийн өсөлт



Монгол Улсын эдийн засаг 2016 онд 1.2 хувь хүртэл буурсан ч 2017 онд 5.3 хувь, 2018 онд 7.2 хувь, 2019 онд 5.2 хувиар өслөө. Уг 5.2 хувийн өсөлтийн 2.4 пунктийг үйлчилгээний салбар бүрдүүллээ

Инфляцын түвшин



Инфляцын түвшин 2016 онд 0.7 хувь болж буурч, 2019 онд 7.3 хувь болж нэмэгдсэн байна. Төгрөгтэй харьцах америк долларын жилийн дундаж ханшийн өөрчлөлт 2018 онд өмнөх оноос 1.3 хувь, 2019 онд 7.7 хувиар нэмэгджээ. Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оноос 2018 онд 22.8 хувь, 2019 онд 7.0 хувиар тус тус өссөн байна.

ДНБ-ийн бодит өсөлт салбараар



МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ - 2019

Зураг:2 ДНБ-ий жилийн өсөлт, хувиар



Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 2019 онд (оны үнээр) 32.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 15.0 хувиар нэмэгдлээ. Салбараар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 2019 онд өмнөх оноос 22.0 хувь, үйлдвэрлэлийн салбарынх 17.0 хувь, үйлчилгээний салбарынх 8.6 хувь, бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 38.5 хувиар тус тус нэмэгдсэн байна

Зураг:2 ДНБ-ий бодит, өсөлт, салбарын оролцоо



ДНБ 2019 онд өмнөх оноос 5.2 хувиар өсөхөд боловсруулах үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөг 137.7 (10.9%) тэрбум төгрөг, хөдөө аж ахуйн салбарынх 100.1 (4.5%) тэрбум төгрөг, дотоод худалдааны салбарынх 169.2 (7.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

БАНКНЫ САЛБАРЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зээл, хадгаламж



Зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны эцэст 13.6 их наяд төгрөг байсан бол 2019 оны эцэст 17.9 их наяд төгрөгт, харин нийт хадгаламж 11.2-14.2 их наяд төгрөгт хүрчээ. Зээлийн өсөлтийн хурдац 2018 онд 25.5 хувь, 2019 онд 5.0 хувь болсон байна. Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2019 онд 10.1 хувь, харин зээл хадгаламжийн харьцаа 2018 онд 1.30, 2019 онд 1.23 болж буурчээ



Банкны салбарын нийт актив 2019 оны 4-р улиралд 35,8 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 0,9 их наяд (+2,6%) төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2,7 их наяд (+0.1%) төгрөгөөр өслөө.



Банкуудын өөрийн хөрөнгө 2019 оны 4-р улирлын байдлаар 3,0 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0,23 их наяд төгрөгөөр буурчээ. Харин банкны салбарын ашиг 4-р улирлын байдлаар 31,6 тэрбум төгрөгийн алдагдалтай байна. Их хэмжээний алдагдал нь Капитал банкны дампуурлаас хамааралтай.




Нийт дотоодын зээл (цэвэр) өссөөр 2019 оны 4-р улирлын байдлаар 16.7 их наяд төгрөг болов. Харин чанаргүй зээлийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна. 4-р улирлын байдлаар нийт чанаргүй зээл 1,8 их наяд төгрөг буюу нийт зээлийн (цэвэр) 10,9%-ийг эзэлж байна.

БАНКНЫ ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛ

Манай банкны Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын баг нь засаглалыг зохистойгоор хэрэгжүүлснээр үр ашигтай хяналтын тогтолцоо, эрх мэдэл, ашиг, орлогын зохистой хуваарилалтыг бий болгож, хөрөнгө оруулагчид, харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалан, тэдний итгэлийг нэмэгдүүлэхийг эрхэмлэн ажиллаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД



Үндэсний хөрөнгө оруулалтын банкны эрх барих дээд удирдлага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

Банкны нийт хувь нийлүүлсэн хөрөнгө:

- 88.9 % - дотоодын хөрөнгө оруулагчид
- 11.1% - гадаадын хөрөнгө оруулагчид

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ДАРГА	С.Оргилмаа
ГИШҮҮД	Ж.Эрдэмбилэг Б.Тулга Хидэтоши Тonoока
ХАРААТ БУС ГИШҮҮД	Н.Мөнхнасан

Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь банк, санхүү, бизнесийн салбарт олон жил ажилласан туршлагатай гишүүдээс бүрдэнэ.

ТУЗ нь банкны бүхий л шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалыг бий болгохын зэрэгцээ аливаа нөхцөлд тохирсон алсын хараа, стратеги бодлогоор банкны үйл ажиллагааг чиглүүлэн ажилладаг.

Үр дүнтэй удирдлага болон хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУЗ нь тус бүрийн үүрэгтэй хороод болон Дотоод аудитын газрыг байгуулан ажиллаж байна.

*Дотоод аудитын газар
Аудитын хороо
Эрсдлийн удирдлагын хороо
Хүний нөөц, цалин урамшууллын хороо*

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



Б.ТУУГА
Гүйцэтгэх захирал



Г.ТӨГӨЛДӨР
Дэд захирал



Ч.БААТАР
Санхүү бүртгэлийн
газрын захирал



С.ГАНБОЛД
Актив, пассив удирдлагын
хэлстийн захирал



Ж.МӨНХЗАЯА
Үйл ажиллагааны
газрын захирал



У.САРАНТУЯА
Сувгийн удирдлагын
газрын захирал



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын хэлтэс нь банкны үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, зохистойгоор удирдах, үүссэн эрсдэлийг хянаж цаг алдалгүй арга хэмжээ авч ажиллах үүргийн хүрээнд оролцож, эрсдэлийг тодорхойлох, зайлсхийх, хянаж бууруулах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. Тус нэгж нь 2019 онд Эрсдэлийн Удирдлагын Алба, Комплаенсын Алба, Мэдээлэл Аюулгүй байдлын Алба гэсэн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

ҮҮНД:

- ▢ Зах зээлийн эрсдэл
- ▢ Үйл ажиллагааны эрсдэл
- ▢ Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл
- ▢ Төлбөрийн чадварын эрсдэл
- ▢ Зээлийн эрсдэл
- ▢ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Банк нь өдөртөө байж болох болон хоног дамжиж болох нээлттэй позицийн хязгаарлалтыг нэг валют болон нийт валютын нийлбэр дүнгээр тогтоон хянаж ханшийн өөрчлөлтөөс учирч болох эрсдэлийг 7 хоног, сараар урьдчилан тооцоолох, ханшийн таамаг хийх эргэн шалгах зэргээр төслэн эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч байна. Мөн хөрөнгийн зах зээлийн анхдагч болон хоёрдогч арилжаа, тэдгээрийн үнэ ханш, өгөөжийн хэмжээг судлан орлого эрсдэлийн зохистой түвшинд хяналт тавин ажиллалаа.

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛ

Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд бодлого журмыг шинэчлэн баталж, ажилтнуудын болон харилцагчдийн мэдээллийн аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх сургалт, зөвлөмжийг тогтмол явуулж, дага орчны аюулгүй байдалд байнгын хяналт хийн, аюулгүй байдалтай холбоотой тайлан мэдээг гүйцэтгэх удирдлагад 7 хоног, сарын давтамжтайгаар тайлагнан, мэдээлэл технологид учирч болох эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар хяналт тавин ажиллаж байна.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Банкны үйл ажиллагааны эрсдлийг удирдах заавар журмыг шинэчлэн боловсруулж үйл ажиллагааны эрсдэлийг риск матрицын аргаар үнэлж удирдахад чиглэн ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд үйл ажиллагааны эрсдэлийн бүртгэлийн програмын хэрэглээг идэвхжүүлж, үйл ажиллагааны эрсдэлийн мэдээллийн баазыг өргөжүүлэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх байдлаар үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ЭРСДЭЛ

Харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх үүднээс ирээдүйн мөнгөн урсгал, төлбөрийн чадварт мониторинг хийх, хөрвөх активыг шаардлагатай түвшинд барих, тогтвортой эх үүсвэр татах замаар энэхүү эрсдэлийг бууруулах, зах зээлийн болон банктай холбоотой стресс хүчин зүйлсийг тооцсон янз бүрийн нөхцөл байдалд үнэлэн хөрвөх чадварын эрсдэлийг цаг үргэлж үнэлэн дүгнэж орох гарах урсгалын стресс тест шинжилгээ, актив, пассивын жигнэсэн дундаж хугацаа болон хугацааны зөрүүгийн шинжилгээг хийх, хөрвөх чадварын дотоод хязгаар харьцаануудыг тооцож үр дүн болон санал, зөвлөмжийг удирдлага болон холбогдох нэгж, хороонд хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Банкны зээлийн эрсдэлийг удирдахдаа зээлийн эрсдэлийг тооцох хяналт тавих журам аргачлалаа сайжруулан зээл болон зээлдэгчид үнэлгээ өгөх, зээлийн багцад Монголбанкны журам, Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын дагуу эрсдэлийн санг байгуулах, Монголбанкнаас тогтоосон болон эрсдэлийн дотоод хязгаарыг хангаж ажиллаж буй эсэх болон зээлийн төвлөрөл, багцын чанар, зээлийн үйл ажиллагааны бүх шатанд хяналт тавих мөн зээл активын үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлаар удирдлагын мэдээллийг тогтмол бэлтгэн хүргүүлж ажиллалаа.

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ


Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлыг хүрээнд Монгол улсын хууль болон олон улсын зөвлөмж, стандартад нийцсэн бодлого журмыг боловсруулан батлаж мөрдөн ажиллаж байна.

Харилцагчийн эрсдэлийг үнэлэх аргачлал, үйл ажиллагааг сайжруулан, эрсдэлтэй харилцагч нарт хяналт тавих, банкны ажилтнуудыг мэдээлэл, заавар, зөвлөмжөөр хангах, сургалт зохион байгуулах зэргээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажиллалаа.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Манай банк Хүний нөөцийн уян хатан, оновчтой бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг. Бидний амжилтын эх үндэс болсон олон мянган харилцагчийн итгэл найдварыг хүлээсэн ажилтнуудаа чадавхжуулах, хөгжүүлэх, зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшуулал олгож, тэднийг ажлын байран дээрээ сурч, хөгжих, нийгмийн асуудлаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх замаар урт удаан хугацаанд тогтвортой, бүтээмжтэй ажиллах орчин нөхцлөөр ханган ажилладаг.

2019 онд банкны бүтэц, зохион байгуулалтад томоохон өөрчлөлт ороогүй ба байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд анхаарч ажиллав.




МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

Мэдээлэл технологийн аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай байдлыг хангах үүднээс өөрийн банкны үндсэн санхүүгийн систем, өгөгдлийн сан, зохих системүүдийн сайжруулалтыг хийж, доголдол үүсэх эрсдэлүүдийг тогтмол хянаж ажиллав. Гадаад гуйвуулгын системийн гүйлгээний нууцлал, аюулгүй байдлыг улам сайжруулан системийг өөрчлөн шинэчлэв. Програм, систем, мэдээллийн санг аюулгүй орчинг бүрдүүлэх, гамшгийн үед сэргээн ажиллах зорилгоор хадгалалт, нөөцлөлтийг тогтмол хийж, боловсронгуй болголлоо. Мөн тайлан мэдээнүүдийг түргэн шуурхай боловсруулж гаргах дээр анхааран ажиллав. ТЕГ, Эрдэнэс Таван Толгой ХК-ийн хувьцаа, Зээлийн мэдээллийн сан, МИК-ын системүүдтэй мэдээлэл солилцох програм, Биллингийн програм зэргийг хөгжүүлж, Цахим банк болон бусад системүүд дээр шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, харилцагчдад тэдгээрийг энгийн болоод хялбар байдлаар хүргэхэд голчлон анхаарч ажиллаж байна.



АУДИТААР БАТАЛГААЖСАН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк ХХК (цаашид “Банк” гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Банкны удирдлага нь 2019 оны 12 дугаар сарийн 31 –ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болох мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлж тайлагнасан болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Банкны удирдлага нь Банкны санхүүгийн тайланг дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвөөр илэрхийлж чадах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглал, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч бүртгэнэ.

Гүйцэтгэх захирал

Б.Гулда

Санхүү удирдлагын газрын захирал

Ч.Баатар

Монгол Улс,

Улаанбаатар хот

2020 оны дугаар сарын өдөр



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Санал дүгнэлт

Бид Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк ХХК (цаашид “Банк” гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлдан жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, мөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний дүгнэлтээр, Банкны санхүүгийн тайлангууд нь 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээнг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Сьандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагын энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЁЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь зүйн зохих шаардлагуудын дагуу Банкнаас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийлүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлэх болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь Банкны удирдлагын үүрэг, хариуцлага юм. Залилан эсвэл алдааны улмаас материаллагаар буруу млэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв тохируулахтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Банкны тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэх, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодрожлэ, Банкны татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааг зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Банкны удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оын 12 сарын 31

сая.төг

Хэвийн зээл	15,628.89	54,685.30
Хугацаа хэтэрсэн зээл	4,277.26	20,052.80
Хэвийн бус зээл	17,647.32	13,830.90
Эргэлзээтэй зээл	9,297.29	26,696.06
Муу зээл	60,995.51	29,335.51
Зээлийн хойшлогдсон төлбөр	(356.06)	(52.13)
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,213.95	15,130.11
Зээлийн эрсдэлийн сан	(67,894.88)	(45,003.44)
Бусад санхүүгийн хөрөнгө	11.88	1,304.83
Бусад санхүүгийн бус хөрөнгө	554.79	26,419.29
Үндсэн хөрөнгө	12,622.05	12,999.01
Борлуулах зориулалттай хөрөнгө	49,992.84	-
Биет бус хөрөнгө	10,101.95	10,156.45
Нийт хөрөнгийн дүн	105,918.50	267,291.18
ӨР ТӨЛБӨР	-	-
Харилцах	80,719.14	28,959.26
Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	80,718.46	28,958.20
Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	0.68	0.07
Хадгаламж	94,368.40	150,101.68
Хугацаагүй хадгаламж	50,342.43	3,589.90
Хугацаатай хадгаламж	36,172.73	135,923.65
Бусад төрлийн хадгаламж	5,498.69	6,373.58
Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	2,354.56	4,214.56





САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оын 12 сарын 31

сая.төг

	2019	2018
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,888.62	54,132.32
Бусад эх үүсвэр	1,928.15	18,497.72
Бусад санхүүгийн өр төлбөр	1,640.99	2,786.92
Бусад санхүүгийн бус өр төлбөр	10,055.37	10,223.12
Нийт өр төлбөрийн дүн	191,600.68	264,700.02
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	-	-
Хувь нийлүүлсэн хөрөнгө	35,130.00	54,200.00
Давуу эрхийн хувьцаа	-	-
Энгийн хувьцаа	35,130.00	54,200.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	4,260.12	4,260.12
Хуримтлагдсан ашиг, алдагдал	(125,072.30)	(55,868.96)
Өөрийн хөрөнгийн дүн	(85,682.18)	2,591.16
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	105,918.50	267,291.18

